



АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2017 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

АУДИТЫН НЭР: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

АУДИТЫН КОД: ҮАГ-НАГ-/2017/03-НА

The screenshot shows the website of the State Audit Agency of Mongolia. The main menu includes: ШИЛЭН ДАНС, ТӨСВИЙН ЕРӨНХӨЙЛӨН ЗАХИРАГЧ, ЯАМ, АГЕНТЛАГ, ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙ НЭЭЖ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, АЖ АХУЙ НЭЭЖ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА, ИРГЭН. The left sidebar has icons for: Эхлэл, Орон нутаг, Мэдээ мэдээлэл, Холбоо барих, Нэвтрэх. The main content area displays a map of Mongolia with red dots indicating audit locations. Below the map is a table listing the audit locations in Bayankhongor aimag.

Улаанбаатар	Баян-өлгий	Баянхонгор	Булган	Говь-алтай	Архангай
Говьсүмбэр	Дархан-уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Хэнтий
Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Хөвсгөл
Сэлэнгэ	Төв	Увс	Ховд		

On the right side, there is a section for Баянхонгор aimag with a list of districts: Баянхонгор аймags-Сум, Баянхонгор сум, Баацагаан сум, Баянбулаг сум, Баянговь сум, Баянхил сум, Баян-Овоо сум, Баян-Өндөр сум, Баянцагаан сум.

Баянхонгор аймагт Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам” бүрэн хэрэгжихгүй байна.

Баянхонгор хот
2017.11.20

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
АУДИТЫН ТАЙЛАН	4
НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН	6
Шилэн дансны тухай хууль хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал сайтад бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан байна.	6
Шилэн дансны тухай хууль хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүд хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийн 92,6 хувь, 6.4-т заасан мэдээллийн 85.3 хувийг мэдээлсэн байна.	7
Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоодын болон хөндлөнгийн хяналтыг төрийн холбогдох байгууллагууд, албан тушаалтнууд хэрэгжүүлж байгаа боловч бүх шатны ИТХ, ИНХ Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.	7
Өмнөх оны аудитаар албан шаардлагаар өгсөн зөрчлийг бүрэн арилгасан хэдий ч зөвлөмжийн биелэлтийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.	7
ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ...	Error! Bookmark not defined.
Тайланг бэлтгэсэн: Баянхонгор аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Аудитын менежер Д.Цэцэгмаа Ахлах аудитор Ё.Сугаррагчаа Аудитор Б.Азбаяр Б.Нарангэрэл	

2017 оны 11 дүгээр сарын 16

Тайланг Баянхонгор аймаг
дахь Төрийн аудитын газрын

Цахим хуудаснаас үзнэ үү:

www.audit.bayankhongor.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар

нэмж тодруулах, асууж

лавлах зүйл байвал
70442584, 70442424
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ: Баянхонгор аймаг
дахь Төрийн аудитын газар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	- ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НАГ	- НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР
НА	- НИЙЦЛИЙН АУДИТ
УИХ	- УЛСЫН ИХ ХУРАЛ
ИТХ	- ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ
ЗДТГ	- ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
СТСХ	- САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС
СХАА	- САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБА
ОНХС	- ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН
ХАА	- ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА
ТЕЗ	- ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
ТШЗ	- ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1.Аудитын нэр: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

2.Аудитын код: ҮАГ-НАГ-/2017/03-НА

3.Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2017 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

4.Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудит хийв.Үүнд:

- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд мэдээлэл хүргэх хэлбэрийг баримтлан, бүрэн хамрагдсан эсэх.
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны мэдээллийг бүрэн мэдээлж байгаа эсэх.
- Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

5.Аудитын хамарсан хүрээ:

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээд, Төрийн байгууллагыг 2015, 2016 онуудад хийсэн аудитын дүн, мэдээлэлд үндэслэн шилэн дансны мэдээлэл 100 хувийн хэрэгжилттэй байгууллагуудад итгэл үзүүлэн аудитаас чөлөөлж, хэрэгжилт хангалтгүй байгууллагуудыг түүвэрлэн 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийг хүртлэх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгав.

6. Үндсэн мэдээлэл

Баянхонгор аймгийн хэмжээнд Шилэн дансны аудитад 2017 оны 3-р улирлын байдлаар 211 байгууллага хамрагдлаа. Аудитын нээлтийн үеэр аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын мэдээллээр Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 2017 оны эхний хагас жилийн байдлаар дүгнэлт хийхэд 23.6 хувьтай гэж гарсан нь тухайн байгууллага мэдээллээ байршуулсан ч админ эрхээр нэвтэрч илгээгээгүй байсантай холбоотой байна.

7. Эрсдэлийн үнэлгээ

Аудитын төлөвлөлтийн явцад цуглуулж судалсан баримт, материал, урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн, хийх аудитын ерөнхий эрсдэлийг **“Дунд”** гэж үнэлэв.

8. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон

Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан хууль хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжийн мэдээллийн самбар болон цахим хуудаст байршуулсан мэдээллийг дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгаж, дүн шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулан аудитын арга зүйг ашиглан, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

9. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд

Дараах хууль эрхийн актуудыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Монгол улсын 2016 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 01 дугаар сарын 11-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”

10. Аудитын хугацаа

Аудитыг 2017 оны 10-р сарын 23-наас эхлэн гүйцэтгэж, мөн оны 11 дүгээр сарын 17-ны өдөр удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 11 дүгээр сарын 20-ны өдөр ҮАГ-ын НАГ-т хүргүүлэв.

11. Аудит хийсэн бүрэлдэхүүн

Аудитыг ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер Д.Цэцэгмаа үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ё.Сугаррагчаа, аудитор Б.Азбаяр, Б.Нарангэрэл нар гүйцэтгэв.

12. Хүндрэл бэрхшээл

Шилэн дансны аудитыг хийх явцад shilendans.gov.mn цахим хуудас ажлын цагаар их ачаалалтай байсан тул гацаж, хүндрэл учирч байв.

Шилэн дансны мэдээллийг хянах эрхээр орж нэгтгэлийг авч байгаа боловч аудитын хавсралт судалгааны маягыг бөглөхөд заавал тухайн байгууллага руу энгийн хандалтаар хандаж байж нарийвчлан үзэх шаардлага үүсч байгаа нь цаг хугацаа ихээхэн шаардагдсан болно.

НИЙЦЛИЙН АУДИТЫН ДҮН

Баянхонгор аймгийн хэмжээнд 2017 оны 3-р улирлын байдлаар хийсэн шилэн дансны аудитад 211 байгууллага хамрагдав.

Бүлэг 1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан эсэх.

Шилэн дансны тухай хууль хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны цахим системд бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан байна.

1.1. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдсан байна.

Баянхонгор аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 - 3.1.3 дахь заалтад хамаарах, урьдчилсан судалгаагаар гарсан төрийн болон орон нутгийн өмчит **209** байгууллага, орон нутгийн өмчит “Баянхонгор эрчим хүч” ЦТ ХХК, “Чандмань-Баянхонгор” ХК, **нийт 211** төсвийн байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансны нэгдсэн портал системд бүрэн хамрагджээ.

Тус аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцэст 212 байгууллага, аж ахуйн нэгж шилэн дансанд мэдээллээ байршуулж байсан бол 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 211 болж хоёр байгууллага хасагдаж, нэг байгууллага шинээр нэмэгдсэн байна. Үүнд:

1/. Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 66 дугаар тогтоол, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017. 04. 06-ны өдрийн № А/86 тоот тогтоолоор Онцгой байдлын ерөнхий газрын харьяа салбар, нэгжийг шинэчлэн баталсан ба энэ тогтоол, тушаалын дагуу “Баянхонгор сум дахь улсын нөөцийн салбарыг Баянхонгор аймгийн онцгой байдлын газрын бүтцэд нэгтгэсэн”.

2/ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамгаалах төв хувийн хэвшлийн статустай болсон тул хассан.

3/. Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэг 2016 онд шинээр ашиглалтад орсон.


1.2. Хууль хэрэгжүүлэгч байгууллагууд шилэн дансны цахим хуудас, мэдээллийн самбартаа шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд “Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэнэ...” гэж заасан ба цахим хуудаст тавигдах шаардлагыг энэ хуулийн 5.1.1 – 5.1.4 дүгээр зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмаар тодорхойлсон. Мөн хуулийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ

хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заасан.

Баянхонгор аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1- 3.1.3 дахь заалтад хамаарах төрийн болон орон нутгийн өмчит 209 байгууллага, орон нутгийн өмчит “Баянхонгор эрчим хүч” ЦТ ХХК, “Чандмань-Баянхонгор” ХК, нийт 211 төсвийн байгууллага, аж ахуйн нэгж дээр дурдсан хууль тогтоомжийн дагуу шилэн дансны мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталж ажилласан байна.

“Баянхонгор эрчим хүч” ЦТ ХХК, “Чандмань-Баянхонгор” ХК “Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа аж ахуйн нэгж, байгууллага” гэсэн заалтад хамрагдан, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 4.2-т заасны дагуу мэдээллээ байршуулж байна.



Бүлэг 2. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газрууд шилэн дансны мэдээллийг хуульд заасан шаардлагын дагуу хугацаанд нь тогтмол мэдээлсэн үү?

Шилэн дансны тухай хууль хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүд хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийн 92,8 хувь, 6.4-т заасан мэдээллийн 85.3 хувийг мэдээлсэн байна.

2.1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийн 92.8 хувийг мэдээлсэн нь өмнөх оноос 7.5 хувиар өссөн байна.

"ТОГТСОН ХУГАЦАА"-нд цахим хуудас, мэдээллийн самбараар тайлагнах мэдээллийн төрөл тус бүрээр нь авч үзвэл:

	Шилэн дансны тухай хуулийн заалт	Байгууллагын тоо	Тухайн мэдээлэл хамааралгүй	Мэдээлбэл зохих	Үүнээс	
					Мэдээлсэн	Мэдээлээгүй
6.1.1	Тухайн жилийн төсөв	209		209	196	11
	ОНХС-ийн төлөвлөгөө	209	189	21	21	
	ХАА-ны төлөвлөгөө	209	100	109	100	9
6.1.3	Дараа жилийн төсвийн төсөл	209		209	183	26
6.1.4	Санхүүгийн тайлан /хагас жил/	209		209	198	11
	Санхүүгийн тайлан /Жилийн эцсийн /	209		209	112	97
6.1.5	ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт	209	81	129	82	47
	Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	209	132	78	68	10
6.1.6	Төсвийн хэмнэлт хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	209	2	207	200	7

Хуулийн 6.1.1 дэх “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ОНХС-ийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны дотор байршуулна” гэсэн заалтын дагуу 209 байгууллага 339 мэдээлэл байршуулахаас 317 мэдээллийг нэгдсэн порталд байршуулж, 6.5 хувь буюу 20 мэдээллийг байршуулаагүй байгаа нь өмнөх оноос өсөх хандлагатай байгаа тул анхаарч ажиллахыг ТЕЗ-д зөвлөв.

Хуулийн 6.1.2-д заасан дараа сарын 8-ний дотор мэдээлвэл зохих төсвийн гүйцэтгэлийн 2691 мэдээллээс 2620-ийг буюу 97.3 хувийг цахим хуудаст байршуулсан байгаа нь өмнөх оны аудитын дүнгээс 0.7 хувиар өссөн байна.

Дараа жилийн төсвийн төслийг 210 төсвийн байгууллага боловсруулсан байгаа ба үүнээс 183 байгууллага мэдээллээ байршуулж, 26 байгууллага мэдээлээгүй байв.

Хуулийн 6.1.4 дэх “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор тогтмол мэдээлнэ.” гэсэн заалтын хүрээнд 209 байгууллага мэдээлэхээс хагас жилийн тайланг 11 байгууллага, 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 97 байгууллага мэдээлээгүй зөрчил илрэв.

Харин зарим төсөв захирагч нар санхүүгийн тайлан болон санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, тайланг аудитын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ цэсэнд байршуулснаас санхүүгийн тайлан байршуулах цэс хоосон орхигдох тохиолдол зарим байгууллага дээр гарсан байна. Иймд мэдээллийг холбогдох цэсэнд оновчтой, зөв байршуулахад анхаарч, арга зүйгээр хангаж ажиллахыг холбогдох албан тушаалтанд зөвлөмжөөр хүргүүлэв.

Хуулийн 6.1.6-д заасан төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбарыг төсвөөс санхүүжилт авдаг 207 байгууллагаас 200 байгууллага мэдээлж, 7 байгууллага мэдээлээгүй байна.

2.2. Шилэн дансны тухай хуулийн 6.4-т заасан мэдээлбэл зохих 2556 мэдээллийн 85,3 хувь буюу 2180 мэдээллийг цахим хуудсанд байршуулжээ.

Шилэн дансны тухай хуулийн 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлнэ” гэж заасны дагуу тайлагнавал зохих нийт 2580 мэдээллээс 2210 буюу 85.7 хувийг мэдээлсэн ба цахим хуудсанд 7404.1 сая төгрөгийн 370 мэдээллийг байршуулаагүй байна.

Аудитад хамрагдсан 211 байгууллагаас тус хуулийн 6.4 дэх заалтад хамаарах 209 байгууллагын мэдээллийг зүйл тус бүрээр авч үзвэл:


Хуулийн 6.4.1-т заасны дагуу 88 байгууллага тухайн жилийн төсвийн хуваарьт орсон нэмэлт өөрчлөлтийг, 6.4.2-т заасны дагуу 6 байгууллага төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсөнд орсон өөрчлөлтийг тухай бүр шилэн дансанд байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.1, 6.4.2, 6.4.6, 6.4.7 дахь заалтуудад заасан мэдээллийг байршуулсан байдлыг хүснэгтээр харуулбал:

6.4-т заасан мэдээлэл	өөрчлөлт орсон эсэх		Мэдээлсэн эсэх	
	Тийм	хамааралгүй	тийм	үгүй
6.4.1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт	88	121	209	0
6.4.2. Тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	6	203	209	0
6.4.6. Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	15	194	209	0
6.4.7. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	21	188	209	

Шилэн дансны тухай хуулийн 6.4.3-т “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн

талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан” –ы мэдээллийг 25 байгууллагын зарласан тендерт оролцсон 179 аж ахуйн нэгжээс шалгарсан 101 аж ахуйн нэгжийн 100 мэдээллийг, шалгараагүй 78 оролцогчийн 32 мэдээллийг шилэн дансанд байршуулсан байна. Дээрх үзүүлэлтээс авч үзэхэд хууль хэрэгжүүлэгч байгууллага нь тендерийн тухай мэдээллийг цахим системд оруулахдаа шалгарсан оролцогчийг байршуулж байгаа боловч шалгараагүй оролцогчийн мэдээллийг оруулахгүй байгаа нь хуулийн 6.4.3 дахь заалт бүрэн хэрэгжихгүй байна.



Шилэн дансны тухай хуулийн 6.4.4-т заасан таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалттай холбоотой 29 байгууллагын 6810.7 сая төгрөгийн 167 гүйлгээнээс, 6651.7 сая төгрөгийн 156 гүйлгээг мэдээлсэн бөгөөд Эрдэм ахлах сургуулийн 5.4 сая төгрөгийн 1 гүйлгээ, Соого сейко сургуулийн 5.8 сая төгрөгийн 1 гүйлгээ, Баянхонгор сумын 1-р цэцэрлэгийн 5.0 сая төгрөгийн 1 гүйлгээ, Баянхонгор сумын 2-р цэцэрлэгийн 65.6 сая төгрөгийн 3 гүйлгээ, Баянхонгор сумын 5-р цэцэрлэгийн 38.9 сая төгрөгийн 1 гүйлгээ, Тэмүжин театрын 38.2 сая төгрөгийн 4 гүйлгээг дутуу мэдээлсэн тул нөхөн мэдээлэх албан шаардлагыг холбогдох төсөв захирагч нарт хүргүүлээ.

Хуульд заасны дагуу 7 хоногт мэдээлэх мэдээллийг харуулбал:

Мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх мэдээлэл	Нийт		Үүнээс: мэдээлээгүй	
	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн
6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл	167	6810.7	11	158.9
6.4.5. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	324	6,806.4	45	547.2
6.4.5. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	1201	38241,0	0	0
6.4.8 Төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл	588	1,512.5		
Нийт	2280	53370,6	56	706.1

Хуулийн 6.4.5-д заасан мэдээлэл буюу тухайн гүйлгээ гарснаас хойш 7 хоногийн дотор ил болгох шаардлагатай цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс

дээш үнийн дүн бүхий зарлагын 54 байгууллагын 6806.4 сая төгрөгийн 324 гүйлгээг шилэн дансанд байршуулахаас 6259.2 сая төгрөгийн 279 гүйлгээг байршуулжээ. Нэр бүхий 23 байгууллагын 547.2 сая төгрөгийн 45 гүйлгээг шилэн дансны нэгдсэн порталд байршуулаагүй тул зөрчлийг арилгах албан шаардлагыг байгууллагын удирдлагуудад хүргүүлэв.



Мөн 87 байгууллагын 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээнд төсвийн зарим байгууллага авсан санхүүжилтийг мэдээлсэн ба зарим нь мэдээлээгүй тул аудитын явцад 6697,9 сая төгрөгийн 267 орлогын гүйлгээг шилэн дансны нэгдсэн портал сайтад нөхөн байршуулав.



2017 оны 09 дүгээр сарын 30-ний байдлаар хуулийн 6.4.6-т заасан “худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, болон бусад хяналт шалгалтын дүн”-г хуулийн 3.1-т хамаарах хяналт шалгалт хийгдсэн 15 байгууллага мэдээллийг шилэн дансанд бүрэн байршуулжээ.

2017 оны эхний 3-р улирлын байдлаар батлагдсан орон тоонд өөрчлөлт орсон 15 байгууллага мэдээллийг байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-д байгууллагууд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг гарснаас хойш 7 хоногийн дотор мэдээлэхээр заасан заалтын дагуу 40 байгууллага 1512.5 сая төгрөгийн 588 шийдвэрийг шилэн дансанд бүрэн оруулсан байна.

2.3. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллээс худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн ерөнхий мэдээллээс өөр ажил гүйлгээ гараагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-т заасан байгууллагад “Чандмань-Баянхонгор” ХК, “Баянхонгор-эрчим хүч” ЦТХХК хамрагдаж байгаа бөгөөд 2017 оны эхний 9 сарын байдлаар хуулийн 6.8.2.-т заасан “Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө...”-г байршуулсан байна.

“Баянхонгор-Эрчим хүч” ХХК нь 2017 онд “Смарт тоолуур худалдан авах”, “Үйлчилгээний авто машин худалдан авах”, “Бетонон тулгуур худалдан авах” тендерийг зохион байгуулж, нийт 6 оролцогч оролцсон ба 3 оролцогч шалгарсан тухай ерөнхий мэдээллийг байршуулсан байна.

Дээрх 2 аж ахуйн нэгжийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6.8-д заасан бусад ажил гүйлгээ гараагүй тул байршуулах мэдээлэл байхгүй байна.

2.4. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан байгууллага, аж ахуйн нэгжүүд хуулийн 6 дугаар зүйлийн 6.9-д заасан мэдээллийг бүрэн оруулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-т заасан байгууллага тус хуулийн 6.9-т заасны дагуу 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр орон нутгийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний судалгааг сумдаас авахад шилэн дансанд мэдээлбэл зохих 20 аж ахуйн нэгжийн жагсаалт гарсан бөгөөд эдгээр мэдээллийг шилэн дансанд байршуулсан эсэхийг шалгаж үзэхэд Баянбулаг сумын ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж буй 10.0 сая төгрөгийн гэрээний үнэ бүхий “Сумын төвийн гэрэлтүүлэг”-ийн ажлыг шилэн дансанд байршуулаагүй байсныг аудитын явцад зөрчлийг арилган залруулав.

Мөн 3.1.5-д заасан байгууллага тус хуулийн 6.9-т заасны дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээний талаарх мэдээллийн судалгааг гаргаж үзэхэд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлж орон нутгаас санхүүжилт авдаг 49 аж ахуйн нэгж, Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлдэг 4 аж ахуйн нэгж, мөн 5 өрхийн эмнэлгийн үйлчилгээний байгууллага нийт 58 аж ахуйн нэгжийн санхүүжилтийн мэдээллийг шилэн дансны портал сайтад оруулсан байна.

Бүлэг 3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлсэн эсэх.

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоодын болон хөндлөнгийн хяналтыг төрийн холбогдох байгууллагууд, албан тушаалтнууд хэрэгжүүлж байгаа боловч бүх шатны ИТХ, ИНХ Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

3.1 Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 - 3.3-д заасан байгууллагууд шилэн дансны тухай хуулийг хэрхэн хэрэгжүүлж буйг 2016.09.31-ний байдлаар тус аймаг дахь Аудитын газраас шалгаад “Шилэн дансны тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасны дагуу бүх шатны ИТХ, ИНХ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүргээ биелүүлэхгүй байна” гэж дүгнэсэн ба дээрх хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгсөн боловч зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүх шатны ИТХ-ын тодорхой нэг албан тушаалтанд хариуцуулж ажиллах талаар аймгийн ИТХ-аас шийдвэр гаргаж, сум, багуудад хүргүүлэх шаардлагатай байна.

3.2 Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг Санхүүгийн хяналт аудитын алба бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2017 оны 6, 10 дугаар сард 2 удаа шалгалт хийж, Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь, үнэн зөв, иж бүрэн мэдээлэх үүргээ хангалтгүй биелүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаагүй 16 сумын төсвийн ерөнхийлөн захирагч, 33 төсвийн шууд захирагчид “Сануулах”, 2 албан тушаалтанд “Албан тушаалын цалинг 1 сар 20 хувиар бууруулах” сахилгын шийтгэл аймгийн Засаг даргын захирамжаар ногдуулжээ.

Гэвч дээрх захирамжаар шийтгэл хүлээсэн Баянбулаг сумын ТЭЗ, ТШЗ нар шилэн дансны цахим системд аудит хийх үед мэдээллийг байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.2, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд зааснаар хяналтыг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба хэрэгжүүлэхээр заасан байтал 2017 оны хагас жилийн байдлаар шалгалт хийсэн боловч тайлан гараагүй, ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

3.3. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын ажлын тайланг дүгнэхдээ шилэн дансны хэрэгжилтийг нэг үзүүлэлт болгон авч үзэж байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангах нэг хөшүүрэг болж байна.

Салбар хариуцсан төрийн захиргааны төв байгууллагууд, босоо тогтолцоотой байгууллагууд орон нутаг дахь харьяа байгууллагадаа хяналт шалгалт хийхдээ шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тухайн байгууллагад үзэж шалгаад, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Тухайлбал: 2017 оны 11 дүгээр сард Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тус аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт шалгалт хийхдээ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан болно. Үүний үр дүнд аймгийн төв дэх байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт жилээс жилд харьцангуй сайжирч байна.

Мөн Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид хамаарах байгууллагуудын санхүүгийн ажилтнуудын ажлыг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс хагас, бүтэн жилээр дүгнэж, ур чадварын нэмэгдэл тогтоох, шагнаж урамшуулахдаа ажлын нэг үзүүлэлт болгон авч үзэж байна.

3.4 Шилэн дансны цахим хуудсыг иргэд ашигладаггүй, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих талаар мэдээлэл муу байна.

Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны мэдээллийг иргэд ашиглаж, хяналт тавьж буй эсэхийг аль ч байгууллагын цахим хуудаснаас харах боломжгүй байна. Иймд шилэн дансны мэдээлэлтэй холбоотой программ хангамжийг цаашид боловсронгуй болгож, “Хандалтын тоо”-г харж болохуйц болгох шаардлагатай байна.

Аудитаар 30 иргэнээс түүвэрлэн судалгаа авахад “Шилэн дансны тухай хуулийн талаар та аль хэр мэдлэгтэй вэ?” гэсэн асуултанд 14 иргэн “дунд зэрэг мэднэ”, 16 иргэн “мэдэхгүй” гэж, “Та төрийн байгууллагуудын цахим хуудас руу орж, шилэн дансны мэдээлэлтэй нь танилцаж, хяналт тавьж байсан уу?” гэсэн асуултад 30 иргэн “үгүй” гэсэн хариултыг өгсөн нь Шилэн дансны портал сайтыг иргэд огт ашиглаж, хэрэглэдэггүй, мэдээлэл хангалтгүй байгааг харуулж байна.

Бүлэг 4. Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

Өмнөх оны аудитаар албан шаардлагаар өгсөн зөрчлийг бүрэн арилгасан хэдий ч зөвлөмжийн биелэлтийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

4.1. Шилэн дансны 2016 онд хийгдсэн аудитаар өгсөн албан шаардлагыг хууль хэрэгжүүлэгч байгууллагууд бүрэн хэрэгжүүлсэн байна.

2016 оны 3-р улиралд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нэгдсэн удирдамжаар хийсэн аудитаар 26 байгууллагад 676.9 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Аудитаар зөрчил гаргасан жагсаалтыг авч шилэн дансны сайтад тулгаж үзэхэд тухайн зөрчил бүрэн арилсан байна.

4.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжөөс аймгийн ИТХурал шилэн дансны тухай хуулийн 8.1 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулаагүй байна.

2016 оны 3-р улиралд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нэгдсэн удирдамжаар хийсэн аудитаар аймгийн Засаг даргад 2, сумдын санхүүгийн албаны дарга нарт 2, нийт 4 заалт бүхий зөвлөмжийг өгчээ. Зөвлөмжийн биелэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжилт
Аймгийн Засаг даргад		
1	Шилэн дансны тухай хуулийн 8.2 дахь заалтын дагуу дотоод хяналтыг тогтмол хугацаанд хийж, хяналтын үр дүнгээс нь хамааруулан хуулийн 10.1-т заасан “Шилэн дансны тухай хууль тогтоомж зөрчсөн төсвийн байгууллагын албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан түүнийг томилсон эрх бүхий этгээд Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2017 оны 6, 10 дугаар сард 2 удаа шалгалт хийж, Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь, үнэн зөв, иж бүрэн мэдээлэх үүргээ хангалтгүй биелүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаагүй 49 албан тушаалтанд “Сануулах”, 2 албан тушаалтанд “Албан тушаалын цалинг 1 сар 20 хувиар бууруулах” сахилгын шийтгэл тус тус ногдуулсан байна
2	Харъяа байгууллагуудын дарга нарт Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7.1, 8.1 дэх заалтыг баримтлан мэдээллийн үнэн зөв байдал, хугацаанд хяналт тавьж ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгч хэрэгжүүлэх.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2017 оны 6, 10 дугаар сард 2 удаа шалгалт хийхдээ арга зүйн зөвлөгөө давхар өгч ажилласан байна.
Сумын засаг дарга, Санхүүгийн албаны дарга нарт		
3	Сумдын Засаг даргын цахим шилэн дансанд хуулийн 6.1.4-д заасан санхүүгийн тайлантай холбоотой мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.	Санхүүгийн тайлантай холбоотой мэдээлэл байршуулалт өмнөх оноос нэмэгдсэн ч зөрчил бүрэн арилахгүй байна.
4	Төсвийн байгууллагуудын дарга нарт Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7.1, 8.1 дэх заалтыг баримтлан мэдээллийн үнэн зөв байдал, хугацаанд хяналт тавьж ажиллах талаар арга зүйн зөвлөгөө өгч хэрэгжүүлэх.	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн сургалтад санхүүгийн албаны албан хаагчдыг хамруулсан.

Аудитаар нийт 706.1 сая төгрөгийн мэдээлэл оруулаагүй зөрчил илэрч, 27 байгууллагад мэдээлэл оруулах албан шаардлага хүргүүлэв.

ДҮГНЭЛТ

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитаар илэрсэн нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт гаргаж байна. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн 3.1.1 - 3.1.3-д заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн портал сайтад бүрэн хамрагдаж, мэдээлэл хүргэх хэлбэрийг баримталсан байна.

2. Шилэн дансны тухай хууль хэрэгжүүлэгч байгууллага хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.-д заасан мэдээллийн 92.6%, 6.4-т заасан мэдээллийн 85.3%-ийг шилэн дансанд байршуулсан байгаа нь хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна.

3. Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудад Шилэн дансны мэдээлэл байршуулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч, арга зүйн талаархи мэдээлэл дутмагаас зарим байгууллагууд шаардлагатай мэдээллийг тохирсон цэсэнд нь байршуулаагүйгээс хоосон мэдээлэл илгээсэн зөрчил илэрч байна.


4. Хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоодын болон хөндлөнгийн хяналтыг төрийн холбогдох байгууллагууд, албан тушаалтнууд хэрэгжүүлж байгаа боловч бүх шатны ИТХ, ИНХ Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

5. Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын шилэн дансны хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба хяналтыг хангалттай хэрэгжүүлэхгүй байна.

6. Өмнөх аудитын албан шаардлагаар өгсөн зөрчил бүрэн арилсан хэдий ч зөвлөмжөөр өгсөн 6.1.4-д заасан санхүүгийн тайлантай холбоотой мэдээлэл болон хуульд заасан бусад мэдээлэл байршуулаагүй, зөрчил давтагдан гарсаар байна.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

НЭГ. АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА Ц.ОТГОНБАЯР ТАНАА

1. Шилэн дансны тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтыг аймгийн ИТХ-ын ажлын албаны нэг ажилтаны, сумдын ИТХ-ын нарийн бичгийн даргын ажлын байрны тодорхойлолтонд нэмж оруулах, энэ чиглэлээр хийсэн ажлынх нь тайланг улирал тутам авч байх, дээрх албан тушаалтнуудын ажлыг нь дүгнэхдээ "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьсан байдал"-ыг харгалзах.

ХОЁР. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.БАТЖАРГАЛ, АЙМГИЙН ЗДТГ-ЫН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА С.БАЙГАЛЬМАА НАР ТАНАА

1. Харъяа байгууллагуудын дарга нарт Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ыг баримтлан мэдээллийг бүрэн байршуулж, хуулийн үйлчлэлд хамаарах байгууллагуудын төсвийн захирагч, санхүүгийн ажилтнуудыг арга зүйгээр хангаж ажиллах

ГУРАВ. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА Б.НАРМАНДАХ ТАНАА

1. Төсвийн байгууллагуудын дарга нарт Засгийн газрын 2016 оны 29-р тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 8.2 дахь заалтыг баримтлан мэдээллийн үнэн зөв байдал, хугацаанд хяналт тавьж, холбогдох ажилтнуудыг арга зүйгээр хангаж зөвлөгөө өгч ажиллах.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 01-р сарын 20-ний дотор албан тоотоор ирүүлнэ үү.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

